



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар Д/154

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Худалдан авах
ажиллагааны алба балансаас хөрөнгө
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 05дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 635,250 (зургаан зуун гучин таван мянга хоёр зуун тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Баянзүрх дүүргийн Соёлын ордон, Нийслэлийн ерөнхий боловсролын 111 дүгээр сургуулийн балансад тус тус шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба (Б.Чулуунбаатар)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Баянзүрх дүүргийн Соёлын ордон (Л.Рэнчинням)-д, Нийслэлийн ерөнхий боловсролын 111 дүгээр сургууль (Л.Ариунболд)-д тус тус үүрэг болгосугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба (Б.Чулуунбаатар)-т, Баянзүрх дүүргийн Соёлын ордон (Л.Рэнчинням)-д, Нийслэлийн ерөнхий боловсролын 111 дүгээр сургууль (Л.Ариунболд)-д тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРАА



115050000469

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 0109/Дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэх н авах байгууллага
Машин, тоног төхөөрөмж											
1	Усны аппа	Monel	8	ш	1	159,990	159,990	159,990	-		БЗД-ийн Соёлын ордон
Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн											
Тавилга, эд хогшил											
2	Хурлын ширээ	Гурвалжин хэлбэртэй, мебель өнгөтэй, ногоон бүрээстэй	8	ш	1	2,310,000	2,310,000	1,674,750	635,250	Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны газар	БЗД-ийн 111 дүгээр сургууль
Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн											
Нийт хөрөнгийн дүн											
									635,250		
									635,250		